

ГАДААДЫН ЭРДЭМТЭД
МОНГОЛЫН ТУХАЙ

**ЯПОНЫ ЭРДЭМТЭД ӨНӨӨГИЙН
МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХУЙГ
СУДАЛЖ ЭХЭЛСЭН НЬ**

О. Оюунгэрэл

БНМАУ-ын хөдөө аж ахуй- газар тариалан, мал аж ахуйн өнөө үеийн хөгжлийн асуудлыг судлах явдалд японы эрдэмтэд анхаарлаа хандуулах болжээ. Монгол дахь нүүдлийн аж төрөх ёс, мал аж ахуйн хөгжлийн талаархи судалгаа бол Японд Монголын судлал эхлэн хөгжсөнөөс хойш монголын нийгмийн түүхийг судлах уламжлалт судалгааны зүйлийн нэг болсон юм. Уг асуудлаар японы эрдэмтэд нэгэн сэдэвт зохиол, судалгааны өгүүлэл олон зууг бичсэнээс тэдгээрийн ихэнх нь хятадын сурвалж бичиг болон БНХАУ-ын Өвөр Монголын нутагт хийсэн мал аж ахуйн хөгжлийн судалгаан дээр тулгуурлан гүйцэтгэсэн байна.

Урьд өмнө монголчуудын аж төрөх ёсыг нүүдэлчид мэтээр нэгтгэн дүгнэж байсан нь одоо үед илэрхий хуучирсан бөгөөд энэ нь Монголын нийгэмд гарсан өөрчлөлтийг тусгахгүй нь илэрхий байна.

Тийм ч учраас, ардын засгийн жилүүдээс хойш монголын ард түмний уламжлалт аж төрөх ёсонд гарсан, гарч буй үндсэн өөрчлөлтийг олон талаас нь гүнзгийрүүлэн судлах нь орчин үеийн монгол судлал дахь нэн чухал чиглэл болоод байна.

БНМАУ ба Япон улсын хооронд дипломат харилцаа 1972 онд тогтсон ба японы эрдэмтдийн хувьд өөрсдийн судалгаанд шаардлагатай ном хэвлэл, сурвалж материалыг ашиглах боломж саяхнаас нээгдсэн явдал нь тэдэнд БНМАУ-ын хөдөө аж ахуйн хөгжлийн асуудлыг үнэн зөвөөр бодит байдлаар нь судлах боломжийг нээсэн тул энэ асуудлаар судалгаа явуулах сонирхолыг нь ихээхэн татсан юм.

1974 онд хоёр орны хооронд байгуулсан соёлын хэлэлцээрийн дагуу монгол, японы эрдэмтэд тухайн газар дээр очиж судалгаа шинжилгээний ажлыг хамтран гүйцэтгэх бололцоотой болжээ. Иймд хөдөө аж ахуйн салбарт явуулах судалгааны хувьд хоёр талын хэлэлцэн тохиролцсон үндсэн дээр дараахь 10 асуудлаар хамтран ажиллахаар төлөв лөгөөнд оруулжээ. Үүнд:

1. Мал аж ахуйн бүтээгдэхүүн, ялангуяа, айраг, тараг зэрэг исгэлэн, мөн түүнчлэн махан төрлийн бүтээгдэхүүнийг ашиглах;
2. Мал аж ахуйн фермийн эрүүл ахуй, ариун цэврийн байдлыг хангах, тухайлбал, амины малын халдварт өвчнийг урьдчилан сэргийлэх арга;
3. Амины малыг шимэгч хорхойноос сэргийлэх, түүнийг устгах арга;
4. Хүйтэн бүсийг судлах, давстай хөрсөнд ургадаг ургамал ногооны Хөгжил ба түүний физиологи;
5. Газар ашиглалт, усжуулалтын системийн зохион байгуулалт, тариалалтын газар талбайг бүрэн бүтнээр нь хамгаалах;
6. Говийг ногооруулах, говьд усан санг ашиглах явдал;
7. Малын үүлдэр шимийг сайжруулах зорилгоор зохиомол хээлтүүлэг хийх;
8. Халуун рашааны дулааныг ашиглан малын хороо, хашаан дахь агаарыг зохицуулах цэвэршүүлэх;

9. БНМАУ дахь нэгдэлжих хөдөлгөөний үйл явц;

10. Монголын газар тариалан, мал аж ахуй эрхлэх уламжлалт аргад хэрэглэгддэг үгийн сан¹ гэсэн гол гол асуудлууд оржээ.

1975 оны 9 дүгээр сард явуулсан анхны хамтарсан судалгаанд японы талаас Окаяма мужийн их сургуулийн профессор, хөдөө аж ахуйн мэргэжилтэн Накаэ Тоситака, Нагахори Кинзо нар оролцсон юм. Тухайн орон нутагт эрдэм шинжилгээний судалгаа явуулахдаа мал аж ахуй эрхлэх арга, түүнийг ашиглах, газар боловсруулах эзэмших үйл явц, мөн түүнчлэн хөдөө аж ахуйн эдэлбэр газарт үр бүтээлтэй ашиглаж эзэмших боломжийг судалж, Япон, Монгол хоёр оронд газар тариалан мал аж ахуйг эрхлэх, шинжлэх ухааны болон практик аргыг нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгыг дээрх эрдэмтэд өмнөө тавьсан юм.²

Т. Накаэ-гийн тусгайлсан судалгаа бол мах, сүү, өндөг, арьс шир, ноос гэх мэт мал аж ахуйн бүтээгдэхүүнээр хүний хэрэгцээг дүүрэн хангахын тулд эрдэм шинжилгээний болон практик судалгааг хийх зорилго бүхий «Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг ашиглах тухай шинжлэх ухаан» юм. Уг эрдэмтэн мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг шинжлэх ухааны үүднээс судлахдаа ялангуяа сүү, мах, өндөг нь япончуудын хүнс тэжээлийн зүйлийг сайжруулахад маш чухлыг бодолцон мөн дагалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинэ технологи эзэмших, япончуудын амьдралд үнээний сүү, түүгээр хийсэн бүтээгдэхүүн хамгийн шим тэжээлтэйд тооцогддогийг харгалзан үзжээ. Иймээс сүүг хэрэглэх, үйлдвэрлэх хэтийн төлөвийг тодорхойлох зорилгоор Накаэ түүнийг үйлдвэрлэх анхдагч эх булаг, сүүг хэрэглэж ирсэн түүхэн нөхцөлийг эрхбиш эргэн үзэхэд хүрчээ. Энэ утгаар сүү үйлдвэрлэлийн түүхийг сөхөн үзвэл Монголоос өөр сүүн бүтээгдэхүүнийг үр ашигтай ашигладаг, гайхамшигтай сайхан сүү цагаан идээг уламжлалт аргаар бэлтгэдэг өөр орон алга. Хэдийгээр энэ нь умардын нүүдэлчин ард түмний амьдралын хэв ёс боловч мал аж ахуйн бүтээгдэхүүнийг хувцас, хүнс, аж амьдралдаа бүрэн дүүрэн ашиглаж чаддаг монголчуудын оюун ухаан, бүтээлч чанарыг хүндэтгэхгүй байхын аргагүй юм»³ гэж Т. Накаэ тэмдэглэжээ.

Накаэгээс өмнө монголын уламжлалт сүү, цагаан идээний талаархи судалгааг 1937 онд японы эрдэмтэн М. Сайто, М. Осима, 1955 онд Умэсао нар Өвөр Монголд хийсэн байна. Умэсао нарийвчилсан судалгааныхаа үндсэн дээр сүү, цагаан идээг үйлдвэрлэх аргын ангилалт бий болгох гэж оролджээ. 1972 онд эрдэмтэн С. Накао сүү боловсруулалтыг 4 ангилал (гашуун, халуун, тослог, хатуу) санал гаргажээ. Одоогийн судалгааны онцлог нь өмнөхтэй харьцуулбал БНМАУ-ын орчин үеийн мал аж ахуйн хөгжилтэй харилцан холбоотойгоор сүү цагаан идээг боловсруулах монгол технологийг нарийн нягт судалсанд оршино. Тухайн асуудлыг японы монгол судлаачид судлахдаа 1924 оноос эхлэн мал аж ахуйг эрхлэн хөтлөх арга ажиллагааг сайжруулах талаар монголын төрийн гүйцэтгэсэн үүрэг ролийг авч үзэхийн сацуу;

— орчин үеийн техник хэрэглэхтэй холбогдон урьдын нүүдлийн мал аж ахуй хэрхэн өөрчлөгдсөн;

— мал сүргийг бэлчээрээр маллах, бэлчээрийн байдал;

— аж ахуйг эрхлэх нүүдлийн бэлчээрийн аргад үндэслэсэн одоогийн мал аж ахуйг цаашид хэрхэн хөгжүүлэх⁴ зэрэг гол гол асуудал дээр анхаарлаа хандуулжээ.

Монголын мал аж ахуйг эрхлэн хөтлөх өвөрмөц онцлогийг К. Нагахори чухалчлан үзэж, юуны өмнө газар зүйн хүчин зүйл, баялаг ур-

гамал бүхий бүх орны газар нутгийн 83 хувийг эзлэх байгалийн бэлэн бэлчээр, мөн хөрсөн доорхи усны их нөөцийг онцлон тэмдэглэжээ.

Т. Накаэ судалгааныхаа өгүүлэлд бичихдээ: «Нүүдлийн нийгэмд суурьшмал газар тариалангийн орных шиг газрыг хувьдаа өмчлөх систем хөгжөөгүй, нийгмийн эдийн засагт нөлөөлдөг цорын ганц капитал нь мал сүрэг юм. 1921 оны хувьсгалын дараа тус орон мал аж ахуйгаа хамтын аж ахуйн хэлбэрт шилжүүлэхдээ ихээхэн бэрхшээлтэй тулгарсан... мал аж ахуй дахь хувийн өмчийг аажмаар устгав. Одоо саланги тусгай зохион байгуулсан хөдөө аж ахуйн бригадууд өвөлд хадлан тэжээл бэлтгэж, европын орнуудын суурьшмал мал аж ахуйн байдлыг олон талаар тодорхойлдог малын тэжээл үйлдвэрлэдэг»⁵ гэж дурджээ.

Түүний үзэж байгаагаар «Мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааны давуу талыг хадгалах, түүнийг орчин үеийн нөхцөлд сайжруулахын тулд байгалийн гэнэтийн аюул зудаас хамгаалах дулаан хашаа саравч барих, мөн малын тэжээл үйлдвэрлэлийг сайжруулахад анхаарал тавих нь онцгой чухал»⁶ байна.

Хөдөө аж ахуйг хөгжүүлэх бааз байгуулахын тулд монголын хээр талын бүсэд хөрс, услалтын системийг судлах нь японы эрдэмтдийн нэг зорилт байв. Хөдөө аж ахуйг цаашид хөгжүүлэхийн тулд монголын бүх нутаг дэвсгэрийн хөрсний шинж чанарыг судлах, тусгай карт зохиох, хадгалахад тохирох атар газрыг сонгож авах, мөн цаг агаарын бүс, усны нөөцийг судлах нь зайлшгүй хэрэгтэй гэж Японы эрдэмтэд үзэж байна.

Хөдөө аж ахуйг хөгжүүлэх асуудлаархи анхны судалгаагаа үргэлжлүүлж, хоёр дахь удаагийн хамтарсан судалгааны ажлыг 1976 оны 6—8 дугаар сард хөрсний судалгаа, өвс, ургамлын судалгаа; сүүн бүтээгдэхүүний судалгаа; хөдөө аж ахуй, мал аж ахуйн үгсийн сангийн судалгаа гэсэн 4 чиглэлээр явуулжээ.

Эрдэмтэн Т. Накаэ Өвөрхангай аймгийн Хархорины сангийн аж ахуй, Өмнөговь аймгийн говийн районд буюу баруун өмнөд Монголд явуулсан 2 удаагийн судалгаагаа харьцуулан үзжээ. Тэрээр монголын мал аж ахуй ба сүү, цагаан идээ үйлдвэрлэх техник, гэрийн малын сүүний химийн найрлагыг судалж, монголын уламжлалт сүү, цагаан идээг урьдчилсан байдлаар ангилав.

Эрдэмтэн К. Нагахори тухайн районы услалтын системийг судалж, хөрсний задлан шинжилгээ хийсэн байна.

Орчин үеийн монголын түүхийг судалж буй түүхч Онуки Масао 1982 онд жилийн турш Өвөрхангай аймгийн Бүрд сумын жишээн дээр БНМАУ-ын хөдөө аж ахуй, хамтрал, сангийн аж ахуйн хөгжлийн талаар эрдэм шинжилгээний судалгаа явуулжээ.

Ийнхүү хамтарсан судалгаа явуулахдаа, эрдэмтэд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт хийхээс гадна, нийгэм, ёс суртахууны шинж чанартай дүгнэлт хийж байна. Тухайлбал, эрдэмтэн М. Онуки Бүрд сумын оршин суугчидтай олон удаа уулзаж ярилцаж, судалгаагаа явуулж байсны үндсэн дээр хөдөлмөрийг хайрлах, байгаль төрсөн газар нутгаа бишрэн хайрлах, найз нөхөрсөг байх, бие биеэ хүндэтгэх, өрөвдөх, хүн хүндээ гүнээ итгэх зэрэг явдал нь өнөөгийн дэлхий ертөнц дээр тогтнох хүний хамгийн гол агуулга гэсэн санааг тодорхой гаргаж иржээ. Энэ утгаар «Онуки-гийн хувьд юуны өмнө зөвхөн судалгаанд төдийгүй, хүний хувьд амьдран явахын гүн ухааныг Бүрдийн хүмүүсээс сурч мэдсэн нь чухал зүйл болно...»⁷ Тэрээр Бүрд суманд жилийн дөрвөн улирал дараалан очиж, японы монгол судлаачдаас анх түрүүн манай хөдөөгийн амьдралыг судлаад «Нүүдлийн мал аж ахуйн орчин үе» хэ-

мээх сонирхолтой ном бичиж нутагтаа хэвлүүлжээ.

Монгол судлаач С. Ватанабэ «Орчин үеийн Монголыг ойлгож мэдэх оньсон түлхүүр нь хөдөө аж ахуйд байгаа нь маргаангүй» гэж монголын эдийн засгийн салбар дахь хөдөө аж ахуйн ролийг онцлон үзэж байна.

Эрдэмтэн И. Каваками «Монголын бэлэг дэмбэрэлийн үгс нь цаг. улирлын солигдолт, мал аж ахуйн нөлөөнд автагдан нүүдлийн мал аж ахуйн явцад «хот айл»-ын холбоог зузаатгах зорилгоор хэрэглэгдэж ирсэн гэж ардын аман зохиолын талаархи судалгаандаа дурджээ.

Сүүлийн үед японы эрдэмтэд монголын хөдөө аж ахуй, тухайлан, нүүдлийн мал аж ахуйн үүсэл хөгжлийг шинжлэх ухааны үүднээс онцгойлон судалж, түүний ач холбогдлыг үнэлэхдээ өнөө үеийн нийгмийн түвшинд зохицуулан хөгжүүлэхийг чухалчлан үзэж байна.

Тэд монголын уламжлалт мал аж ахуйг анхааран судлахдаа, түүний Монголд төдийгүй, мөн Японд ч ашигтай эсэхийг нотлон харуулахыг оролдож байна. Үүний нэг жишээ бол 1985 оны 4 дүгээр сард Японы Осака хотын Монгол судлалын төвийн дэргэд «Нүүдэлчин нийгмийн газар нутгийг судлах аяллын групп»-ийг нээж ажиллуулсан явдал юм. Үүний зорилго нь Монголын нүүдлийн мал аж ахуйг Японы хөдөө аж ахуй, тосгоны байдалтай харьцуулан судлах явдал юм. Монголын түүхийг судалж мэдэхийн тулд өөрсдийн дэргэдээс судалгаагаа эхлэх хэрэгтэй, ялангуяа өөрийн ойр орших мал аж ахуйг судалж мэдсэний үндсэн дээр гадаад орны судалгааг хийх нь ашигтай гэж японы эрдэмтэд үзжээ. Уг групп байгуулагдсанаасаа хойш японы 2—3 мужийн (Хёго, Нара, Тоттори) мал аж ахуй эрхэлдэг газар, фермүүдээр явж бэлчээр, хариулгын зохион байгуулалт, цагаан идээ боловсруулах талаар тодорхой судалгаа хийжээ.

Японы эрдэмтдийн дээрх судалгаа шинжилгээний ажил нь үйлдвэрлэлийн өргөн хүрээтэй зорилтыг хамарч, бодит үр дүн болон гарч ирэх гэж байна. Монголын бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг судлах, боловсронгуй болгох, техник хэрэгсэл нэвтрүүлэх, хөдөөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар судалгааны ажил явуулах зорилгоор Япон улсад «Говь болон нүүдлийн аж ахуй нийгмийн бүс нутгийг судлах, хөгжүүлэх төсөл», товчоор хэлбэл «Говь» төслийг эрхлэх төв байгуулагдав.

Уг төслийг санаачлан байгуулсан эрдэмтэд, бүх ажлын шинжлэх ухааны үндэслэлийг урьдчилан нарийн тогтоохыг хамгийн гол гэж үзэж байна. Тэд 1993 оноос ирээдүйн гол чиглэлүүдийг тодорхойлох бөгөөд суурь судалгааны зэрэгцээ сүү, цагаан идээ, малын мах, тарваганы мах боловсруулах, хадгалах технологи бий болгох, үйлдвэр байгуулах, нарны энерги, салхины хүч ашиглаж бага зардлаар цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх зэрэг практик зорилтыг шийдвэрлэх гэж байна.

1. К. Нагархори, Монгору-ни окэру кансоти ногё-но дзидзё төса, (Монголын тал хээрийн бүс нутаг дахь хөдөө аж ахуйн байдлын судалгаа). «Кайхо» 1976. 3. (No 7), х. 2—3
2. К. Нагахори. Монгору-ни окэру кансочи ногё-но жижё чёса, «Кайхо». 1976, 3 (7). х, 2 :
3. Т. Накаэ. Монгору-но бокутику то нюсэйхин, (Монголын мал аж ахуй ба сүүн бүтээгдэхүүн). «Кайхо». 1976, 3 (No 7) х. 10
4. С. Миоки. Монгору-но бокутику-ни цуйтэ (Монголын мал аж ахуйн талаар). «Кайхо». 1977. No 7 (8), х 35
5. Т. Накаэ. Монгору-но бокутику то нюсэйхин, «Кайхо». 1976, 3 (No 7) х 10
6. Мөн тэнд, х. 12
7. «Монгору кэнкю» (Монгол судлал). 1984. No 7. Осака, х. 110—111